



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2026.06.11

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	2026 оны зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1	Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар дахь үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод эсэхэд улирал тутам дүн шинжилгээ хийх, дутуу мэдээллүүдийг байршуулах, тус арга хэмжээг хэвших	Хувь	80%	Тус төв нь цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр улирал тутам шинжилгээ хийж, дутуу мэдээллийг байршуулж, хяналт тавьж ажиллаж байна. 2025 оны 4 дүгээр улирлын “Шилэн индекс”-ийн үнэлгээг 2026 оны 1 дүгээр улирлын үнэлгээтэй харьцуулж үзвэл мэдээллийн ил тод байдал 8% сайжирсан байна.  67% Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Баталгаажсан үнэлгээний огноо: 2026-01-16	70%

				 75% Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Баталгаажсан үнэлгээний огноо: 2026-04-22 ЭХЭМҮТ-ийн цахим хуудас нь анх 2009 хийгдсэн ба өнөө үеийг хүртэл бүтцийн өөрчлөлт хийгдээгүй ирсэн билээ. Цахим хуудас хуучирсан технологээр хийгдсэн нь нэг төрлийн мэдээлэл нэг доор байрлах боломж муутай байсан. Хэрэглэгч мэдээлэл хайж олоход хүндрэлтэй байсан. Мөн тус цахим хуудас байрлах сервер компьютерт мэдээлэл хадгалах төхөөрөмжний /HDD/ алдаа илэрч зарим мэдээллүүд дуудагдахаа болсон. 	
--	--	--	--	--	--

				Зураг 1.Хуучин цахим хуудас. Дээрх хүндрэлүүдийг засах зорилгоор шинээр цахим хуудас хийлгэхээр төлөвлөгөөнд оруулан хэрэгжүүлсэн. Шинэ цахим хуудсыг 2026 оны 1 улиралд “Содон солюшн” ХХК-аар үнийн харьцуулалтын үр дүнд сонгон хийлгэсэн. Төлөвлөсөн санхүүжилт 10 сая ₮ байсан боловч, байгууллагаас шаардлагатай программ хангамж, лицензийн төлбөр болох 2,75 сая ₮ гарсан ба үлдэгдэл санхүүжилтыг ар гэрийн гишүүдийг эрүүл мэндийн үзлэгт оруулах үйлчилгээгээр харилцан тохиролцсон.  Зураг 2.Шинэ цахим хуудас. Одоо шинэ цахим хуудасаа контентээр дүүргэж байна. Нийт байх естой мэдээллийн 85% оруулсан. 1/VII хүртэл үлдсэн мэдээллүүдийг 2	
--	--	--	--	--	--

				улирлын Ил тод байдлын мэдээлэлтэй хамт оруулж дуусгана. Шилэн дансанд мэдээлэл оруулах эрхтэй ажлаас чөлөөлөгдсөн хэрэглэгчдийг одоо томилогдсон ажилчдаар сольж хоцроосон мэдээллүүдийг оруулах үүрэг даалгавар өгсөн. • Хугацаандаа мэдээллэсэн-57 • Хугацаа хоцорч мэдээллэсэн-4 Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 3,4-р сар Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1-р сар, Байгууллагын батлагдсан төсөв 1-р сарыг тус тус хоцроож мэдээллэсэн. • Мэдээллээгүй -8 Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт 3,4,5-р сар Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 3,4,5-р сар Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 5-р сар	
--	--	--	--	--	--

				Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 5-р сарыг тус тус мэдээллээгүй зөрчилтэй байна. Шилэн дансанд хагас жилийн байдлаар 83 мэдээлэл оруулахаас 61 мэдээ оруулсан нь 73 хувьтай байна. Тасаг нэгж бүр өөрийн хариуцсан мэдээллийн самбарт мэдээллийг тогтмол шинэчлэн ажилладаг.	
2	Байгууллагаас хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин, олон нийтэд сурталчлах	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд түгээсэн мэдээллийн тоо, зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн тоо	-Хэвлэл мэдээллийн хэрэгслээр улирал бүр 3-аас доошгүй мэдээлэл гарсан байна. -2-оос доошгүй удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна. -Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулсан байх	1. ЭХЭМҮТөвийн пэйж хуудас, вебсайтын тасралтгүй үйл ажиллагааг хангах хүрээнд өдөр бүр цаг -агаарын мэдээ болон эмчийн зөвлөгөө долоо хоног бүр сэтгэл зүйчийн зөвлөгөө,нийгмийн эрүүл мэндийн зөвлөмж зэргийг улирал тутам “ЭХЭМҮТ үзүүлж байна” влог, мөн цаг үеийн мэдээлэл, сургалт, өдөрлөгийн фото болон reel мэдээг тогтмол хүргэн ажилласан. Үүний үр дүнд 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар пэйж хуудасны дагагчдын тоо 92,000 болж, 2025 оны 12 дугаар сарынхаас 4,456-аар буюу 5.1 хувиар өссөн байна. Ажлын хэрэгжилт 100 хувьтай байна. 2. Нээлттэй хаалгааны өдрийн хувьд Эрүүл мэндийн яамнаас 2026	50%

				оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын өдөрлөгийн үйл ажиллагаа амжилттай явагдаж, өнөөдрийн үзлэг, зөвлөгөөнүүд өгч ажиллаа. Тус өдрүүдэд: Өсвөр үеийн эмчийн үзлэг, зөвлөгөө, Эмэгтэйчүүдийн эмчийн зөвлөгөө Хоол зүйчийн зөвлөгөөг нийт 60 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж, 120 гаруй иргэнд эрүүл мэндийн боловсрол олгох гарын авлага, мэдээллийн материалыг түгээж ажиллав.	
3	Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан эерэг бичлэг, сэтгэгдэл, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	Хамтран ажилласан олны танил хүний тоо, хийлгэсэн сурталчилгааны тоо	Олны танил 5-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх	- Олны танил контент бүтээгч Одзаяа нь Dr.Oral Mongolia брэндийн хамтаар ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн зөвлөх поликлиникд зөөврийн шүдний аппарат хандивласан. Энэхүү аппаратыг ашигласнаар хөгжлийн бэрхшээлтэй, аутизмтай болон хэвтрийн хүүхдүүдэд үзүүлэх шүдний тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, жилд дунджаар 1000 гаруй хүүхдэд чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн. - Одзаяа өөрийн цахим хуудас болон нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан тус үйл	50%


				ажиллагаа болон ЭХЭМҮТ-ийн хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр үзүүлж буй тусламж, үйлчилгээний талаар олон нийтэд сурталчилж, байгууллагын үйл ажиллагааг таниулах, эерэг имижийг түгээхэд дэмжлэг үзүүлсэн.	
4	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах	-нийт албан хаагчдын баталгаа гаргасан байдал /хувиар/ -сургалтын тоо	- бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх -2-оос багагүй сургалт	Тус төв нь Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, МУ-ын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгавар “ Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлыг 2026 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэлээ. 1. Тус төв нь ажилчдын ирц бүртгэлд Able soft ХХК-ийн нүүр уншигч төхөөрөмжийг ашигладаг бөгөөд сар, улирал бүр хяналт хийж асуудал хариуцсан дэд захирал, тасгийн эрхлэгч нарт танилцуулдаг. Төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах ажилчдын санал хүсэлтийн дагуу нэмэлтээр гар утасны аппликэйшн /19.900.000 төгрөг/ ашиглан ажлын цагаа	80%

бүртгүүлэх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр ажилчдын ажлын цагийн нягтаршил сайжирч байна.



ЭХ ХҮҮХДИЙН ЗРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Ажилчдын ирц бүртгэл 2026 оны 2 улиралд 63,3%



2026 оны 3 дугаар улиралд Able soft программын шинэчлэлийн ажил дуусахаар ТАЦН-д байгууллагын ирц бүртгэлийн программыг цалингийн программтай холбох хүсэлт гаргаж, ажилчдын ирц бүртгэлийг цалинтай нь холбохоор төлөвлөсөн.

2. Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах үүднээс эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, ашиг сонирхлоос ангид

				байх зарчмын хүрээнд ажилчидтай хийх ёс зүйн гэрээг боловсруулан 2026 оны 01 дүгээр сард нийт албан хаагчидтай анх удаа “Ёс зүйн гэрээ”-г байгуулсан. Нийт албан хаагчдын хамрагдалт 100%. 3. Төрийн болон албаны нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд “Нууцын баталгаа”-ны хуудас боловсруулан 2026 оны 01 дүгээр сард нийт албан хаагчдаар нууцын баталгаа гаргуулсан. Нийт албан хаагчдын хамрагдалт 100%. 4. Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа” боловсруулсан. “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”-г нийт 56 тасгийн эрхлэгч, албадын дарга нартай байгуулсан. 100%	
--	--	--	--	--	--

				“Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г ажилчдаар гаргуулах зорилгоор боловсруулсан ба 2026 оны 3 дугаар улиралд ажилчдад танилцуулж, баталгаа гаргуулахаар төлөвлөсөн. 5. 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран “Ёс зүйгээр үлгэрлэсэн байгууллагын соёлыг бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга АУ-ны доктор, дэд профессор Д.Оюунбилэг, гишүүн АУ-ны доктор, дэд профессор Ч.Батнайрамдал, Ш.Алтанцэцэг, Ш.Оюунчимэг нар удирдан Төвийн захирал, 4 дэд захирал, 201 ажилтан хамрагдлаа.	
--	--	--	--	--	--

					
--	--	--	--	---	--


				6. 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг зохион байгуулж, сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлоос ангид байх талаар хууль эрхзүйн мэдлэгийг Хуулийн зөвлөх Ч.Болдбаатар, Хүний нөөцийн албаны дарга, ёс зүйн сургагч багш Б.Мөнхшүр нар хамтран орсон. Сургалтын үед Мэдүүлэг, мэдэгдэл,
--	--	--	--	--

тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага тарааж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэрээ байгуулсан.



					
5	Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийх, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах	Хийсэн дүн шинжилгээ, үр дүнд суурилан зохион байгуулсан арга хэмжээний тоо	-Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх - Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх	Хүүхдийн зөвлөх поликлиникт үзлэгийн цаг авах үйлчилгээтэй холбоотой иргэдийн санал хүсэлт их байсан тул 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 11-ны өдөр хүртэл нийт ажлын 5 өдөр ажлын байрны зураглал хийж ажиллав. Хүүхдийн зөвлөх поликлиникин цахим бүртгэлийн үйлчилгээ нь нийт 4 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Бүртгэлийн ажилтан нэг үйлчлүүлэгчид дунджаар 40 секундээс 3 минут 50 секунд хүртэл хугацаа зарцуулж байнх. Энэхүү хугацаа нь үйлчлүүлэгчийн мэдээллийг цахим системд бүртгэх, шаардлагатай мэдээллийг шалгах, үйлчлүүлэгчдэд чиглүүлэг өгөх зэрэг үйл ажиллагаанаас хамааран өөр өөр байна. Ажлын цаг ашиглалтын бүтэц	70%

Ажилтны 8 цаг буюу 480 минутыг юунд зарцуулж буйг харуулсан диаграмм



Тулгамдаж буй асуудлууд:

- Эмнэлгийн утсаар цаг олгох **1800-1901 дугаарын үйлчилгээ** зарим тохиолдолд алдаатай мэдээлэл өгдөг. Тухайлбал, буруу тасагт цаг олгогдох, давхардсан цаг өгөх зэрэг алдаа гарч байна. Үүний улмаас эмчийн үзлэгийн дараалалд давхардал үүсэх, үйлчлүүлэгчдийн хооронд үл ойлголцол, маргаан гарэх нөхцөл бүрддэг.
- Үйлчлүүлэгчдийн дарааллыг зохицуулах зорилгоор ашиглаж буй **дугаар дуудлагын машин** зарим тохиолдолд алдаатай ажиллаж байгаа нь ажиглагдсан. Жишээ нь: **3 дугаар бүртгэгчээс дуудсан дугаар 1 дүгээр бүртгэлийн дэлгэц дээр харагдах** зэрэг

				алдаа гардаг нь үйлчлүүлэгчдийг төөрөгдүүлэх, дарааллын зохион байгуулалтад хүндрэл учруулж байна. <u>Тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга зам:</u> SMS баталгаажуулалт: Үйлчлүүлэгчид утсаар цаг авахад тасаг, эмч, цагийн мэдээллийг багтаасан баталгаажуулах мессеж илгээнэ. Дугаар дуудагч машины алдаа: Дэлгэц дээрх дугаар зөрөх алдааг засахын тулд програмын тохиргоог IT инженерээр шалгуулж, засуулан хэвийн үйл ажиллагааг хангах 1800-1901: Эмнэлгийн утсаар цаг олгох үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудыг чадавхжуулах, мэдээлэл олгох сургалтыг ХЗП-тэй хамтран зохион байгуулах ингэснээр буруу тасагт цаг олгогдох, давхардсан цаг өгөх зэрэг алдаа гарах явдлыг бууруулах боломжтой. Ажиглалт хийсэн 5 хоногийн хугацаанд 4 бүртгэлийн ажилтан өдөрт 600-850 үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байна. Нэг ажилтанд ногдох	
--	--	--	--	---	--

				үйлчлүүлэгчийн тоог өдөрт дунджаар 150-212 хүн гэж үзвэл: • Ажлын цаг: Өдрийн 8 цагийн ажлын хугацаанаас цайны цаг болон техникийн завсарлагыг хасаад үзвэл 7 цаг (420 минут) бүртгэлд зарцуулна гэж тооцов. • Нэг хүнд зарцуулах хугацаа: 1 үйлчлүүлэгчийг бүртгэх дундаж хугацааг 1 минут 30 секундээс - 3 минут гэж үзвэл нэг ажилтан 7 цагт 140-280 хүнд үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой байна. Дээрх тооцооллоос харахад цахим бүртгэлийн ажилтнуудын нэг хүнд зарцуулж буй хугацаа болон өдрийн гүйцэтгэлийг харьцуулан үзэхэд одоогийн ачаалал нь бүрэн зохицуулагдах боломжтой хэвийн түвшинд байна гэж дүгнэсэн. Харин шинээр эрэмбийн ажилтан гаргаж ажиллуулах шаардлагатай байна. иймд эрэмбийн ажилтныг сургаж бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.	
6	Албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа	Зохион байгуулсан сургалт,	2-оос багагүй нөлөөллийн ажил зохион байгуулах	2026 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Үйлдвэрчний эвлэлийн хороо, ЭБАТ нар хамтран 110	70%

	авах нь авлигын зөрчил болох талаар сургалт , нөлөөллийн арга хэмжээг тусгайлан зохион байгуулах (кейс бүхий дэвжээ, АХА бусад уралдаан тэмцээн зохион байгуулж болно.)	нөлөөллийн ажлын тоо		ажилтанд сургалт орж, АХА тэмцээн зохион байгуулав. Сургалтаар ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны дарга Э.Энхнаран ёс зүйн хичээл, Эрх бүхий албан тушаалтан Б.Мөнхшүр ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар хичээл зааж, ҮЭХ асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулав. Тэмцээний ТЭРГҮҮН байранд ЭТТ-ийн инженер Б.Бадамгарав (Өргөмжлөл, 200.000 төгрөг), ДЭД байранд их эмч О.Даваажав (Өргөмжлөл, 100.000 төгрөг), ГУТГААР байранд сувилагч Б.Оюунгэрэл (Өргөмжлөл, 100.000 төгрөг) нар шалгарсан. 
--	--	-----------------------------	--	---

					
7	Харьяа төрийн байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээнд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнгээс хамаарах арга хэмжээ зохион байгуулах	Судалгаа, үр дүнд суурилан зохион байгуулсан арга хэмжээний тоо	Сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнд суурилсан арга хэмжээ зохион байгуулсан байх	ЭМТҮЧАБА-ны даргаар батлуулсан хуваарийн дагуу 2026 оны эхний хагас жилд: 2026 онд ЭМС-ын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж үйлчилгээний онцлогт тохируулан хэвтэн эмчлүүлэгч, амбулаторийн үйлчлүүлэгч, сэргээн засах эмчилгээний тасаг, яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг шинээр боловсруулан, QR хэлбэрээр болон цаасан хэлбэрээр	60%

				хослуулан судалгааг авч ажилласан. 2. Судалгааг ЭМТҮЧАБА-ны даргаар батлуулсан хуваарийн дагуу төвийн 15 тасгийн 1162 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг авч ЭМТҮЧАБА-ны дарга, чанарын менежерүүдээр хянуулж баталгаажуулж, зөвлөмж өгч ажилласан. 3. Судалгаанд хамрагдсан 1162 (100%) үйлчлүүлэгчдээс хэвтэн эмчлүүлэгсэд нийт 504 (43.4%), амбулаторийн үйлчлүүлэгчид 658 (56.7%) байна. 4. Судалгааны үзүүлэлт болох маш сайн сэтгэл ханамжтай, их сэтгэл ханамжтай, дунд зэрэг сэтгэл ханамжтай, сэтгэл ханамж бага, огт сэтгэл ханамжгүй үзүүлэлтүүд болон үйлчлүүлэгчдээс ирсэн саналын дагуу зөвлөмж бичүүлж, ЭМТҮЧАБА-ны даргаар баталгаажуулсан тухайн тасгийн тайлангийн хувийг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, хариуцсан чанарын менежер, Сувилахуйн албаны дарга, тухайн тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хүргүүлж ажилласан.	
--	--	--	--	--	--

				5. Сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг QR хэлбэрээр нийт 37 тасгуудад өгч, цахимаар судалгаанд хамрагдах боломжийг бүрдүүлсэн. 6. ЭМТҮЧАБА нь судалгааг цаасан 552, цахим 610, нийт 1162 үйлчлүүлэгчдээс судалгааг авч ажилласан байна. Үйлчлүүлэгчдээс нийт 401 санал ирсэн. Үүнд: 1. Талархал болон ажлын амжилт хүссэн – 65 санал (24.9%) 2. Ээлтэй орчин бүрдүүлэх талаар – 55 санал (21.1%) 3. Тасгийн өрөө болон 00-ийн цэвэрлэгээ сайжруулах – 50 санал (19.2%) 4. Тусламж үйлчилгээ сайжруулах талаар хүссэн – 38 санал (14.6%) 5. Хоолны талаар – 28 санал (10.7%) 6. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах – 10 санал (3.8%) 7. Тоног төхөөрөмжийн талаар – 8 санал (3.1%) 8. Хүний нөөцийн талаар – 7 санал (2.7%)	
--	--	--	--	--	--

				Үйлчлүүлэгчдээс ирсэн нийт 261 саналыг дүгнэн үзэхэд тасгийн өрөө болон ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах талаар 50 санал (19.2%), тусламж үйлчилгээг сайжруулах талаар 38 санал (14.6%), хоолны чанар, хүртээмжийг сайжруулах талаар 28 санал (10.7%) тус тус ирсэн нь давамгайлж байна. Үйлчлүүлэгчдээс ирүүлсэн санал, сэтгэл ханамжийн судалгааны муу болон маш муу үнэлгээний үр дүнд үндэслэн Чанарын менежерүүд судалгаанд хамрагдсан 15 тасагт давхардсан тоогоор 110 удаагийн зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Нэгтгэн дүгнэж үзэхэд зөвлөмжийн агуулга дараах байдалтай байна. Үүнд: 1. Тусламж үйлчилгээ сайжруулах-эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хийж буй ажил үйлчилгээ, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд сайтар тайлбарлан ойлгуулах-39 (35.5%) 2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй-35 (31.8%)	
--	--	--	--	---	--

				3. Цэвэрлэгээ сайжруулах-18 (16.4%) 4. Ээлтэй орчин бүрдүүлэх-14 (12.7%) 5. Хоолны амт, чанар сайжруулах-4 (3.6%) Үйлчлүүлэгчдээс ирсэн санал, муу болон маш муу үзүүлэлтэд үндэслэн Чанарын менежүүрүүд сэтгэл ханамжийн судалгаа авсан 15 тасагт давхардсан тоогоор 110 удаагийн зөвлөмжийг өгч ажилласан.	
8	Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал асуулга авч, түүний үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авах	Авсан судалгаа, хамрагдсан албан хаагчийн тоо, үр дүнд үндэслэн зохион байгуулсан арга хэмжээний тоо	-Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх -Үр дүнд үндэслэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	2026 оны 3 дугаар улиралд судалгаа авч, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа” гаргуулахаар төлөвлөсөн.	50%
9	Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт нөлөөллийн ажлын тоо	1 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх	2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг зохион байгуулж, сургалтын үед Хуулийн зөвлөх Ч.Болдбаатар манай төвийн кейс болох фэйсбүүкээр тарсан өвчний түүхийн талаар ярьж холбогдох хууль эрхзүйн асуудлыг танилцуулж, албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн	60%

				шинжтэй үйлдэл болох талаар тайлбарлан ойлгуулж, тасгийн эрхлэгч, албадын дарга нарт өөрийн удирдлага дор ажилладаг тасгийн албан хаагчдад мэдээлэл өгөхийг зөвлөсөн.	
10	Удирдлагын зүгээс авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлж, олон нийтэд энэ тухай мэдээлэх	Удирдлагын зүгээс мэдээлэгчийг хамгаалахаа нийт албан хаагчдад мэдэгдэж, мэдээлэл өгөх сувгуудыг сурталчлах Тийм бол “1”, үгүй бол “0”	Удирдлагын зүгээс мэдээлэгчийг хамгаалахаа нийт албан хаагчдад мэдэгдэж, мэдээлэл өгөх сувгуудыг сурталчилсан байх. Энэ талаар олон нийтэд ил тод мэдээлсэн байх	Тус төвийн захирал Ж.Отгонбаатар нь авлига, ашиг сонирхлоос ангид байхыг уриалсан болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, сэргийлэх зорилгоор ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл өгсөн мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ илэрхийлж бичлэг хийлгэсэн. Одоогоор бичлэгийн засварыг хэвлэл мэдээллийн ажилтан Э.Төгөлдөр хийж байна. Бэлэн болмогц төвийн цахим хуудсанд байршуулна. Мөн QR код уншуулан мэдээлэл илгээх, мэдээлэгчийн нууцыг хадгалах, хамгаалах боломжийг бүрдүүлэхээр Мэдээллийн технологийн инженер Ж.Баянсан ажиллаж байна.	70%
11	Байгууллагын удирдах албан тушаалтнаас нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг	Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо	Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх	2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг зохион байгуулж, сургалтын үед Захирал давхар ажил эрхэлж буй албан хаагч заавал ажил олгогчид мэдэгдэж зөвшөөрөл авах тухай сануулж, улсын эмнэлэгт албан хүсэлтээр зөвлөхөөр ажиллаж байгаа	50%

	санал санаачилгыг дэмжин ажиллах			ажилчдаас бусад хувийн эмнэлэгт ажлын бус цагаар ажиллаж байгаа хүмүүст зөвшөөрөл өгөхгүй, өгсөн зөвшөөрлөө цуцалж байна гэдгээ илэрхийлсэн. Үүнтэй холбоотой тасгийн эрхлэгч, албадын дарга нар санал хэлж, харилцан ярилцаж, хуулийн зөвлөх холбогдох хуулийн хориглох заалтыг танилцуулсан үр дүнтэй ажиллагаа болсон.	
12	Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг байгууллага бүр бүрэн хэрэгжүүлж ажиллах	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байх	2026 оны эхний хагас жилийн байдлаар 80% гүйцэтгэлтэй -1 70% гүйцэтгэлтэй -4, 60% гүйцэтгэлтэй -2, 50% гүйцэтгэлтэй -4 ажил байна.	2026 оны эхний хагас жилийн дундаж гүйцэтгэл 61.8%

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА Б.МӨНХШҮР